



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/458

Мандалговь

Газар эзэмшүүлэх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, 33 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлах тухай Сайнцагаан сумын ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын 3 болон 9 дүгээр багийн нутаг дэвсгэр байршилтай 1800 м.кв (0,18га) газрыг хавсралтад заасан иргэдэд худалдаа үйлчилгээний зориулалтаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488191242

